



СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

213200 Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг
Утас/Факс: 7036-3834

ᠠᠨᠠᠨᠠ ᠐1.31 № ᠐᠙ᠭᠭ

танай _____-ны № _____-т

┌ СУМДЫН ЗАСАГ ДАРГА НАРТ ┐

Аймгийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн "Иргэдийн эрүүл мэндийн хамгааллыг сайжруулах, зарим үйл ажиллагааг түр хязгаарлах тухай" А/16 тоот захирамжийг хүргүүлж байна.

Хэрэгжилтийг хангаж ажиллана уу.

Хавсралт 2 хуудастай.



ДАРГА Ө.СУВДАА



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 30 өдөр

Дугаар А/16

Сүхбаатар сум

Иргэдийн эрүүл мэндийн хамгааллыг
сайжруулах, зарим үйл ажиллагааг түр
хязгаарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 “в”, 29 дүгээр зүйлийн 29.1.6 “а”, “л”, “ж”, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.4, 11.1.8, Эрүүл ахуйн тухай хуулийн 11 дүгээр зүйл, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн “Шинэ коронавирусийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 30 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Томуу, томуу тест өвчний өвчлөл, тархалт болон Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдөр хүртэлх хугацаанд Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад тус тус үүрэг болгосугай. Үүнд:

1.1. Иргэн, хуулийн этгээдээс зохион байгуулах олон нийтийг хамарсан арга хэмжээ, жагсаал цуглааныг бүртгэх үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоох, энэ талаар иргэн, аж ахуй нэгж, байгууллагад мэдэгдэх, сурталчлах ажлыг зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ө.Сувдаа/, сумдын Засаг дарга нарт

1.2. Ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, бүх шатны сургалтын төв, цэцэрлэгүүдийн үйл ажиллагааг түр хаасан шийдвэрийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, харгалзах хүнгүй, гэртээ үлдсэн хүүхдүүдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сургалтын хөтөлбөрийн дагуу цахим сургалтыг зохион байгуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын дарга /Ч.Жаргалсайхан/, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга /П.Оюун/, Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа /А.Энхбат/ нарт

1.3. Олон нийтийг хамарсан хурал, цуглаан, сургалт, спортын тэмцээн, уралдаан, аялал зугаалга, урлаг, соёл, жолооны курс, цахим болон бага насны хүүхдийн төрөл бүрийн тоглоомын газрын үйл ажиллагааг түр зогсоох, сургууль,

цэцэрлэгийн насны хүүхдүүдийг албан байгууллага, олон нийтийн үзвэр, үйлчилгээний газраар дагуулж явах, үйлчлүүлэх, үйлчлэхийг хориглох, энэ талаар иргэн, хуулийн этгээдэд мэдээлэх, сурталчлах, хяналт тавьж ажиллахыг аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын дарга /Ч.Жаргалсайхан/, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга /П.Оюун/, Биеийн тамир, спортын газрын дарга /У.Батмөнх/, сумдын Засаг дарга нарт

1.4. Аймгийн нутаг дэвсгэрт "Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл"-тэй худалдаа, үйлчилгээний газрын үйл ажиллагаа эхлэх цагийн хуваарийг богиносгож, 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн өглөөний 08.00 цагаас шөнийн 22.00 цаг хүртэл ажиллахаар түр цагийн хязгаарыг мөрдүүлж, захирамжийг хэрэгжүүлж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газрын дарга /Ж.Отгонхүү/, Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа /А.Энхбат/, сумдын Засаг дарга нарт

1.5. Хууль тогтоомжийн хүрээнд шаардлагатай арга хэмжээ авч, нийгмийн хэв журмыг сахиулах, иргэд, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, хяналт тавих ажлыг зохион байгуулж, нийтийн эзэмшлийн гудамж талбай, замын хөдөлгөөний камерын хяналт ашиглалтыг сайжруулж ажиллахыг Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа /А.Энхбат/, сумдын Засаг дарга нарт


1.6. Томуу, томуу төст өвчний өвчлөл, тархалт болон Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах ажлыг тогтмол зохион байгуулах, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, яаралтай тусламжийн болон байнгын бэлэн байдлыг хангаж ажиллахыг аймгийн Эрүүл мэндийн газрын дарга /Ж.Од/-д

1.7. Байгууллага бүр эрүүл мэндийн зөвлөгөө, халдвараас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, зөвлөмж өгөх ажлыг тогтмол зохион байгуулах, ажилтнууд үйлчлүүлэгчдийг гараа халдваргүйжүүлэх нөхцөлөөр хангах, амны хаалтын хэрэглээг хэвшүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, банк, санхүүгийн байгууллага, аж ахуй нэгж, иргэний нийгмийн байгууллагуудын удирдлагуудад

1.8. Томуу, томуу төст өвчлөл, тархалт, Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээний талаарх мэдээллийг иргэдэд тогтмол, нэгдсэн байдлаар хүргэх ажлыг зохион байгуулахыг сумдын Засаг дарга нар, аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Б.Энхбат/ нарт тус тус үүрэг болгосугай.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлага, мэдээллээр хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ж.Сайнцог/, Засаг даргын Тамгын газрын дарга /Ө.Сувдаа/ нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ